



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар

18/15

Номгон

Г “Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн
жил”-ийн ажлын тайлангийн тухай

“Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил”-ийн ажлын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 18 дугаар хуралдаанаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

“Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/05, жилийн ажлын төлөвлөгөөг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/130 дугаар захирамжаар тус тус батлан хэрэгжүүлж ажилласан байна. Дээрх төлөвлөгөөнд нийт 5 багц 65 ажлыг тусгаж одоогийн байдлаар биелэлт 89 хувьтай байна гэж тайлагнаж байна. Үүнд:

1. “Хүүхдэд ээлтэй засаглал, удирдлага зохион байгуулалт” 13 ажил хэрэгжилт-90,8%, /ажлын цагийн горимд өөрчлөлт оруулах, хүүхдийн сан 50-60%/
2. “Хүүхдэд ээлтэй орчин, хүүхэд хамгаалал” 17 ажил-95,8%, /цахим тоглоомын газар, мини парламент 70%/
3. “Хүүхдэд ээлтэй өрх, хүүхдийн хүмүүжил төлөвшил” 20 ажил-93,5%, /гэр бүлд зөвлөн туслах нэгж сум бүрт байгуулах, өглөө бүр дасгал хөдөлгөөн хийх, шар карт хэрэгжүүлэх зэрэг ажлуудын хэрэгжилт 50%/
4. “Хүүхдэд ээлтэй боловсрол” 5 ажил-68%, /цэцэрлэг сургууль бүр стандартын эко талбай ногоон байгууламж, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм ЕБС-ын гаднах ногоон байгууламж байгуулах—40-50%/
5. “Хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ” ажил 10-88,0%, /хүүхдийн клиник сувилалтай болох, 0-17 насны хүүхдийн нэрээр хянах, гэр цэцэрлэг түшиглэн хүүхдийн сувилал байгуулах зэрэг ажил 40-50%/

Тайлант оны үлдэж буй хугацаанд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ажлын төлөвлөөний биелэлтийг 95 хувьд хүргэнэ гэсэн урьдчилсан тооцоог гаргасан байна.

1190042

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит ХҮИИ хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил"-ийн ажлын тайланг "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсүгэй.

2. "Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил"-ийн ажлын хүрээнд хийгдсэн сургалт, судалгааны үр дүнг тогтвортой хадгалж, цаашид үйл ажиллагаандаа ашиглаж, хүүхдийн хамгаалал, хөгжил, оролцоо, хүмүүжил төлөвшлийг дээшлүүлэх ажил арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР